

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ширваагийн Доржсүрэн	Дугаар	L202
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Дэлгэрэх сум
Төрсөн газар	Дэлгэрэх сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Аварга Гуулингийн хийд, Цагаан хадны хийд	Сүм хийдийн дугаар	ДГДГ 129, ДГДГ 128
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Аварга гуулингийн хийд, Цагаан хадны хийд

Аварга гуулингийн хийд тэгээд энэ Дэлгэрэх сумын талаар ярилцлага хийх гэж байна. За та ингээд өөрийгөө танилцуулаад энэ хийдүүдийн талаар товч мэдээлэл өгнө үү?

Доржсүрэн: За би яахав Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын унаган хүүхэд. Эртэд хааны үр ач, тэрнээс одоо арван гурав, дөрөв дэх үе нь гэсэн юм байх. За тэгээд одоо би өөрийнхөө шүтлэгтэйгийнхээ хүчинд ч гэдэг юмуу ах дүүс орон нутгийнхан дундаа энэ хийд байсан газрыг муу мэддэг юм. Зарим нэгэн газрын шүтээнийг нь мэддэг юм. Чандманий хийдийг бол, Цагаан хад гэдэг газар хийд байгуулаад тэгээд яахав шүтээн сахиусаасаа болж зөрөөд тэгээд хоёр хэсэг хуваагдаад нэг хэсэг нь тэр хойшоо нүүгээд, нэг хэсэг нь Цагаан хаддаа үлдсэн юм гэдэг. Цагаан хадад үлдсэн тал нь бол тэр Чандманийн хийд гэж байгуулсан юм гэсэн. Тийм , тэр дуган гүний угсааны хоёр хүн байгуулсан. За Аварга гуулингийн хийд бол бүр 1660 оны үед хятадын амбаны тушаалаар л одоо монгол улсад бараг албаар шахуу тийм шарын шашны хийд байгуулсан юмуу даа. Одоо монголчуудыг номхруулах гэж. Тэгээд тэр Манжийн хааны хишгээр гэдэг нь тэр юу юм билээ лам нар нь цалин хөлстэй. За одоо тухайлах юм бол, тэр хэдэн лам байдгийн, 20 ламтай ч байдаг юмуу, 200 ламтай ч байдаг юмуу, тэгээд лам нарыхаа тоогоор 3 цэн ч байдаг юмуу, 5 цэн ч байдаг юмуу тэгж мөнгөөр цалинжуулдаг . Тэгээд тэр чинь монгол орны алдартай хийд л байсан гэсэн, анхан байгуулагдахдаа. Тэгээд энийг байгуулагдсанаас хойш тэр цагаан хадтэгээд л зүүн цэг нь тэр зүүн уртраг гэдэг Чандманиас урагшаа холбоо гэж бий, холбоо дэлттэй холбоо гэсэн байхаа. Аа дуган дацан нь болохоороо тэр жинхэнэ гарал үүсэл нь Цагаан чулуутын хийд гэж энэ зүүн зоод. За тэгээд баруун тал нь болохлээр зэрэг тэр Цагаанхадны баруун тал нь Сайхан цагаан уул гэж Сайхан хад гэж тийм хийд бий. Тэгээд энэ Аварга гуулингийн хийд маань өөрөө шүтээнтэй, ширээний тийм хувилсан ламтай, Эрт үеэс алдарсан Намжидын Намхай гэж Ахай Намхай гэж хувилгаан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр Цагаан чулуутын хийд бол бас хутагт хувилгаантай.Хамгийн сүүлийнх нь наян хэдэн оны үед, наяд оны эх, далаад оны сүүлээр нас барсан. Дашням хувилгаан гэж бий.Энэ зүүн хэсгийн Цагаан чулуутын хийдийн хувилгаан.Хөөрхий одоо шорон оронд орж явсан л юм гэнэ лээ. Өөрөө бас нэлээн сайн чадалтай эрдэмтэй хүн байсан тулдаа амьд мэнд гарсан шиг байгаа юм. Ийм юм ярьдаг байсан. Тэгээд энэ Гомбо шүтээтэй. Тэр үзүүрт байгаа, баруунд байгаа Шар усны хийд гэдэг нь Жамсран бурхан шүтээнтэй .Тэр жамсран бурхан нь одоо шүтээн нь, одоо манайхан ярьдаг юм.Жаажээ гээд хөгшинд хадгалаастай.Ямар ч байсан нууц байх ёстой, дэлгэж үзэж харж болохгүй тийм бурхан байгаа. Жамсран чинь өөрөө тийм дошгин бурхан. Төрөх эмэгтэй хүнээс бас хол байлгадаг.Ийм бурхан байх юмаа.Ийм харж болдоггүй одоо хуйлаастай тийм бурхан.Чандманийн хийдийг чинь одоо сайн мэдэхгүй дээ.38 онд л хурал сүм хийд шатаагдаж барихад л тэр том юуг нь , бурхныг нь янгиатай морин дээр, янгиа гэдэг нь одоо сул эмээлтэй морин дээр ачааллана гэсэн үг шүү дээ.Одоо тэгж ачааллаж яваад л уурлахдаа том голын үерт урсгачихсан .Тэр том голыг нь сайн мэдэхгүй. Тэгээд л сүүлд 92 онд манай энэ арван хэдэн хүн тариачид буцах үед л их үер болж байсан газар юм гэсэн.Тэнд л одоо аваачиж үерт урсгасан юм гэдэг. Тэр одоо өштэй байгуулсан бурхан шүтээний хийд байсан юмуу, яагаад тэгсэн юм тэр сайхан том зээгт наамал бурхныг чинь...

Гантулга: Ямар бурхан билээ?

Доржсүрэн: Загь, зээгт наамал Загь гэж бурхан байсан юм. Жалаатын хөндийд багатахгүй гэхээр их хүнд юм л байсан байлгүй. Сономын Лувсан гэж сүүлд одоо их л мундаг байсан даа. Гадаад мадаадын элчин явдаг , дипломат их л мундаг хүн байсан. Тэр хүн бас хүүхэд ахуй цагтаа энд шавилж суугаад явсан. Тэгээд аймагт, академид яваад тэгээд дээшээгээ дарга сайд болсон хүн юм гэсэн. Энэ бурхны хийдүүд бол их олон аймагтай. Их л олон янз бүрийн юмтай, эмч домч, аграмб , маарамбын газартай.Ихээхэн л юм байсан юм гэсэн. Одоо тэгээд нарийн юмыг нь мэдэхгүй. Хүмүүс л тэгж ярьдаг байсан юм. Бага байхад одоо аймгийн найман жилд байхад дээр үеийн улсууд их л юм ярьдаг байсан юм .Тэд нарыг нь ч би нээх юм боддоггүй байсан юм , тоодоггүй байсан,янз янзын юм ярьдаг л байсан. Одоо бодоход бас хэмжээтэй дамжаатай юм бодогддог л байсан . Үгүй одоо энэ

За одоо энэ Чойрын ном бол байна. Чойрын дацан яг цувж хийж байсан байгаа юм.Тэр зүүн чойрт чиг л сурж байсан , баруун Чойрт чиг л сурж байсан. Тэр Нүдээ гэж бас байдаг байсан. Тэр Нүдээ гэдэг нь манай энэ Дорноговиос цааш. Өлгий хийд гэж бас байдаг байсан .Тэр Өлгий хийд нь одоо жинхэнэ хурал бясалгалын нь газар байсан юмуу, яахав дээ тэр номын бараа хийдэг гэж байсан юм.....

Тэгээд л одоо манай Чандманий хийдэд....сайн юм ч байгаа, муу юм ч бас байх юм даа одоо.Манай Чандманий уулын баруун энгэрт энд бол одоо 90-ээд оны үед манай хамгийн өндөр настай Чойжил маарамба байж байгаад нас барсан даа.Энийг одоо би бас цөөн хүнтэй ярьсан юм байгаа юм, Чандманий уулын баруун хотгор гэсэн чинь...Манай Чандманий лам нар нэлээн сайн бичиж байж , номоо.Тэгээд тэр Энэтхэг мэнэтхэгт яваад ирсэн нэлээн сайн хүн байсан гэж байгаа.Тэгээд манай хойд хийд чинь бас номоо хийхдээ жаахан муудаад...Тэгээд энд байсан тэр гадаадаас ирсэн, Энэтхэг яваад ирсэн тэр том ламтайгаа хараалын

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юмхийлцэхдээ тулаад л ...Тэгээд тэр усных нь л юманд хараал хүрчихсэн гэж ярьдаг юм билээ.Тэгээд 38 он болоод голцуу тэр шашин шүтлэг унах шахсан...Ер нь лам нарын л зөрчлөөс болсон гэж ярьдаг юм ш дээ. Тэгээд манай эндхийн лам нарын зөрчлөөс болоод ...Шашныхан нэг нэгнийгээ хараахаар чинь энд хурал хурж болохгүй л гэж надад тэр өвгөн хэлж байсан юм, би сайн мэддэггүй юм Тэр утгаараа миний гаргах гэж байсан хүн гэж гавж болчихсон.Тийм л хараал хийж байж л даа. Одоо нөгөө 2 хүн нь гавж болж чадаагүй байхгүй юу.2 биенээ гавж болгож чадаагүй , гэхдээ нөгөө шашных нь одоо үндсийг бууруулах шалтгаан л гэж бодож л дээ.Тэднуус л одоо тэр хүдгийнх нь юунд хараал хэлээд тэгээд тэр хараалыг нь гаргаж байсан юм гэнэ лээ